

Агуулга

Оршил

Нэг. Ойлголт, тодорхойлолт

Хоёр. Аж үйлдвэрийн салбар

Гурав. Барилгын салбар

Дөрөв. Зам, тээвэр

Тав. Холбоо

Хүснэгтийн жагсаалт

1. Бүртгэлтэй аж ахуйн нэгж байгууллагын тоо, салбараар
2. Үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагын тоо, салбараар, ажиллагчдын тооны бүлгээр
3. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт, оны үнээр, тэрбум төг
4. Бүтээгдэхүүний үйлдвэрлэл, салбар, дэд салбар, дүнд эзлэх хувиар
5. Аж үйлдвэрийн мэдээнд хамрагдсан аж ахуйн нэгж, иргэдийн тоо
6. Бүтээгдэхүүний үйлдвэрлэл, гол нэр төрлөөр, биет хэмжээгээр
7. Аж үйлдвэрийн салбарын ажиллагчдын тоо
8. Аж үйлдвэрийн салбарын хөдөлмөрийн бүтээмж, салбар, дэд салбар, мян төг
9. Барилга угсралт, их засварын ажил, оны үнээр, сая төг
10. Барилга угсралт, их засварын ажил, сая төгрөг, сумаар
11. Ашиглалтанд оруулсан орон сууц, м2, оны эцэст
12. Авто тээврийн үзүүлэлт, оны эцэст
13. Тээврийн хэрэгслийн техникийн хяналт, оношлогоонд хамрагдсан тээврийн хэрэгслийн тоо, сумдаар, оны эцэст
14. Холбоо шуудан, оны эцэст
15. Телефон утасны сүлжээний байршил, 2016 оны 12-р сарын 31-ний байдлаар
16. Үүрэн телефоны үзүүлэлт, оны эцэст

Зургийн жагсаалт

1. Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж байгууллагын тоо, ажиллагчдын тооны бүлгээр, дүнд эзлэх хувь
2. Бүтээгдэхүүний үйлдвэрлэл, сая төгрөг
3. Бүтээгдэхүүний борлуулалт, сая төгрөг
4. Нийт үйлдвэрлэлт, салбараар
5. Нийт борлуулалт, салбараар
6. Барилга угсралт, их засварын ажил, төрлөөр, мян төг
7. Ашиглалтанд оруулсан орон сууцанд амьдарч буй өрх, хүн амын тоо

Дүгнэлт

ОРШИЛ

Газар зүйн байрлалын хувьд эх орны өмнөд хязгаарт 109,4 мян.км² нутгийг эзлэн, урд талаараа БНХАУ-тай баруун, хойд, зүүн талаараа Өмнөговь, Дундговь, Говьсүмбэр, Хэнтий, Сүхбаатар аймгуудтай хиллэн оршино. Аймгийн нутаг бүхэлдээ говийн бүсэд багтдаг боловч нутгийн өмнөд хэсэг нь говь, хойд хэсэг нь говь хээр хосолсон нутаг юм. Аймгийн нутаг эх газрын хувьд эрс тэс уур амьсгалтай.

Тус аймгийн нутгаар Улаанбаатар-Сайншанд-Замын-Үүдийг холбосон 726 км, Сайншанд-Зүүнбаян өртөө хүртэл 47 км, нийт 770 гаруй км үргэлжилсэн төмөр замаар ачаа, зорчигч тээн аймгийн төвийг улсын нийслэлтэй болон өмнөд хөрштэй холбодог юм. Энэ замын дагуу Айраг, Даланжаргалан, Өргөн, Эрдэнэ, Замын-Үүд зэрэг төмөр замын өртөө суурин бий. Бусад сумдад хүн, шуудан, ачаа тээврийг авто машинаар гүйцэтгэж байна.

Дорноговь аймгийн бүх сумд цахилгаан эрчим хүчний нэгдсэн сүлжээнд бүрэн холбогдсон бөгөөд үйл ажиллагааг Чойрын ЦТСС, УБТЗ-ын ЭХУХ-ийн 2-р анги, Дорноговь ЦССалбарууд тус тус хариуцан ажиллаж байна.

Дорноговь аймаг ашигт малтмалаар баялаг бөгөөд хайлуур жонш% гөлтгөнө, чулуун нүүрс, газрын тос, алт, зэс никел, төмөр, марганец, хром, гянт болд, цагаан тугалганы зэрэг 38 төрлийн ашигт малтмалын 73 орд, 440 гаруй илэрцүүд тогтоогдсон бөгөөд уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэрлэл хөгжих нөхцөл бүрдэж байна.

Тус аймагт 1940 оны дунд үеэс анхны үйлдвэрүүдийн суурь тавигдсан бөгөөд гар үйлдвэрийн артель, хүнсний үйлдвэр, хэвлэх үйлдвэр эхлэн байгуулагдсан юм. 1960-1980 онуудад мод боловсруулах үйлдвэр, эрчим хүчний үйлдвэр, нэгдэл дундын үйлдвэр, барилгын материалын үйлдвэр, уулын баяжуулах үйлдвэрүүд байгуулагдсан бөгөөд 1980-аад оны дунд үеэс карьер боловсруулах үйлдвэр, хүнсний бусад үйлдвэрүүд байгуулагдсан билээ. Зах зээлийн эдийн засагт шилжсэн 1994 оны дунд үеэс тус аймагт жижиг үйлдвэр эрхлэх идэвхи санаачлага эрс нэмэгдсэн билээ. 1991, 1992 онд улсын үйлдвэр байсан мод, ахуйн үйлчилгээний чиглэлийн үйлдвэрүүд хувьчлагдан, хэд хэдэн жижиг үйлдвэр байгуулагдсан юм. Тухайлбал: 1992 онд ахуйн үйлчилгээний чиглэлийн жижиг үйлдвэр Айраг суманд 2, Даланжаргалан суманд 1, Дэлгэрэх суманд 2, Иххэт суманд 1, Мандах суманд 1, Хатанбулаг суманд 1, Хөвсгөл суманд 1, Сайншанд суманд 3 тус тус ажиллаж байжээ.

НЭГ. ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Аж үйлдвэрийн салбар

Аж үйлдвэрийн салбар нь эдийн засгийн үйл ажиллагааны ангиллын дагуу уул уурхай, олборлох аж үйлдвэр, боловсруулах аж үйлдвэр, цахилгаан, хий, дулаан, уур усан хангамж гэсэн гурван салбараас бүрдэж байна.

Аж үйлдвэрийн салбарын эдийн засгийн үзүүлэлтэд аж ахуйн нэгж байгууллагуудын ажиллагчид, зардал, бүтээгдэхүүний үйлдвэрлэлт биет хэмжээ, үнийн дүнгээр, бүтээгдэхүүний борлуулалт, үндсэн хөрөнгө болон санхүүгийн байдлыг харуулсан үзүүлэлтүүдийг оруулдаг. Тэдгээр үзүүлэлтүүдийг гаргах мэдээллийн эх сурвалж нь үйлдвэр газруудын сар улирал, жилийн тайлан юм.

Бүтээгдэхүүн: гэж бусад бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэлтэд завсрын хэрэглээний орц хэлбэрээр, эсвэл хүн амын эцсийн хэрэглээ болж ашиглагдах зорилгоор үйлдвэрлэлийн үр дүнд бий болсон биет зүйлийг хэлнэ.

Нийт үйлдвэрлэлт: гэж аж ахуй нэгж байгууллага, иргэдийн өөр нэгж байгууллагын хэрэгцээнд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулан үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний нийт хэмжээг хэлнэ.

Нийт борлуулалт: гэж тайлангийн хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажи үйлчилгээг хэлнэ.

Аж үйлдвэрийн борлуулалт: гэж энд зөвхөн тухайн аж ахуй нэгж, байгууллагын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалтыг хэлнэ. Өөрөөр хэлбэл үйлдвэрлэлийн бус бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний болон үндсэг хөрөнгө, түүхий эд, материал нэх мэт зүйлийг худалдан борлуулсан хэмжээг оруулахгүй.

Тээврийн салбар

Тээврийн салбарын статистик үндсэн үзүүлэлтүүд ачаа эргэлт, тээсэн ачаа, зорчигч эргэлт, авто машины тоо, шилжүүлсэн тонн.км ажиллагсадын тоо орлого зэрэг орно.

Ачаа эргэлт: Нийт тээвэрлэсэн ачааны хэмжээг зөөвөрлөсөн зайгаар үржүүлсэн үзүүлэлт

Зорчигч эргэлт: Нийт зорчигчдын тоог тээвэрлэсэн зайгаар үржүүлсэн үзүүлэлт

Шилжүүлсэн тонн.км: Тээврээр гүйцэтгэсэн олон түрүл хэлбэрийн ажил үйлчилгээг тусгай коэффициентийг ашиглан нэг нэгжид шилжүүлж тооцно.

ХОЁР. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР

Манай аймгийн хэмжээнд 2016 оны байдлаар 1177 аж ахуйн нэгж, байгууллага бүртгэлтэй байгаагаас 1002 аж ахуйн нэгж нь үйл ажиллагаагаа тогтмол явуулж байна.

ХҮСНЭГТ 1. БҮРТГЭЛТЭЙ АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ТОО, салбараар


Салбарын ангилал	2012	2013	2014	2015	2016	2016 2015
БҮГД	905	983	1088	1065	1177	110.5
Хөдөө аж ахуй	36	35	39	34	39	114.7
Олборлох үйлдвэр	14	12	16	15	17	113.3
Боловсруулах аж үйлдвэр	48	55	54	49	52	106.1
Цахилгаан хий үйлдвэрлэл, ус хангамж	2	2	10	1	2	200.0
Барилга	23	31	40	37	45	121.6
Бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн, барааны засварлах үйл ажиллагаа	245	276	280	330	352	106.7
Зочид буудал, зоогийн газар	79	86	84	77	78	101.3
Тээвэр агуулахын аж ахуй, холбоо	37	49	75	54	61	113.0
Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа	74	85	85	82	91	111.0
Үл хөдлөх хөрөнгө, түрээс бизнесийн үйл ажиллагаа	53	54	58	22	25	113.6
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын үйл ажиллагаа	53	52	54	62	63	101.6
Боловсролын салбарын үйл ажиллагаа	63	63	65	76	78	102.6
Эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	61	61	56	37	41	110.8
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	117	122	172	189	233	123.3

2016 онд үйл ажиллагаа явуулж байгаа 1002 аж ахуйн нэгжээс аж үйлдвэрийн салбар буюу уул уурхайн олборлох үйлдвэр, боловсруулах үйлдвэр, цахилгаан хий үйлдвэрлэл, усан хангамжийн салбарт 71 ААН үйл ажиллагаа явуулж байна.

ХҮСНЭГТ2. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ТОО, салбараар, ажиллагчдын тооны бүлгээр


Салбарын ангилал	2016	Ажиллагчдын тооны бүлэг			
		1-9	10-19	20-49	50+
БҮГД	1002	784	102	83	33
Хөдөө аж ахуй	25	22	3		
Олборлох үйлдвэр	9	8			1
Боловсруулах аж үйлдвэр	34	30	3	1	
Цахилгаан хий үйлдвэрлэл, ус хангамж	2				2
Бохир ус, хог хаягдлын менежментийн болон цэвэрлэх үйл ажиллагаа	6	4		1	1
Барилга	36	23	4	7	2
Бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн, барааны засварлах үйл ажиллагаа	276	262	9	2	3
Тээвэр агуулахын аж ахуй, холбоо	45	36	2	4	3
Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	61	47	10	4	
Мэдээлэл холбоо	18	16	2		
Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа	65	64		1	
Үл хөдлөх хөрөнгө, түрээс бизнесийн үйл ажиллагаа	24	23	1		
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	35	29	3	2	1
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	20	16	4		
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгал	63	28	8	21	6
Боловсролын салбарын үйл ажиллагаа	66	17	18	21	10
Эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	39	12	18	8	1
Урлаг, үзвэр, тоглоом наадам	26	22	3		1
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	152	125	14	11	2

ЗУРАГ 1. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ТОО, ажиллагчдын тооны бүлгээр, дүнд эзлэх хувь




2016 оны жилийн эцсийн байдлаар нийт 1002 аж ахуй нэгж байгууллага үйл явуулж байгаа бөгөөд 1-9 ажилчидтай аж ахуй нэгж 78 хувь, 10-19 ажилчидтай аж ахуй нэгж 10 хувь, 20-49 ажилчидтай аж ахуй нэгж 8 хувь, 50-аас дээш ажилчидтай аж ахуй нэгж 4 хувийг тус тус эзэлж байна.

ЗУРАГ 2. БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, сая төгрөг




Аж үйлдвэрийн салбарт 2016 оны жилийн эцсийн байдлаар 35998.5 сая төгрөгийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэжээ. Нийт үйлдвэрлэлт нь өмнөх оноос 3.4² дахин өссөн байна.

ЗУРАГ 3. БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОРЛУУЛАЛТ, сая төгрөг




2016 оны жилийн эцэст 55132.1 сая төгрөгийн бүтээгдэхүүнийг дотоод гадаад зах зээлд борлуулжээ. Нийт борлуулалт өмнөх оны мөн үеэс 4.3 дахин өссөн байна. Үйлдвэрлэл, борлуулалтын өсөлтөнд уул уурхай, боловсруулах аж үйлдвэрлэлийн салбаруудад шинээр үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуй нэгжүүд нэмэгдсэн нь нөлөөлж байна.

ЗУРАГ 4. НИЙТ ҮЙЛВЭРЛЭЛТ, салбараар



2015 онд бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 72.1 хувийг УУГ, 20.8 хувийг компани, 6.4 хувийг өрхийн аж ахуй, 0.7 хувийг хоршоо тус тус үйлвэрлэсэн байна. 2016 онд бүтээгдэхүүн үйлвэрлэлтийн 25.1 хувийг УУГ, 1.6 хувийг өрхийн аж ахуй, 73.3 хувийг компаниуд үйлдвэрлэжээ. Энэ нь өмнөх оны мөн үеэс УУГ 47.0 пунктээр,

ЗУРАГ 5. НИЙТ БОРЛУУЛАЛТ, салбараар



компани 52.5 пунктээр өсч, өрхийн аж ахуй 4.8 пунктээр буурсан байна. 2016 онд бүтээгдэхүүний борлуулалтын 12.4 хувийг УУГ, 86.1 хувийг компани, 1.5 хувийг өрхийн аж ахуй эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс УУГ 27.1 пунктээр, өрхийн аж ахуй 3.5 пунктээр буурч, компани 31.3 пунктээр өсчээ.

ХҮСНЭГТЗ. АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОРЛУУЛАЛТ, оны үнээр, тэрбум төг

	2012	2013	2014	2015	2016
Улсын дүн	6058.0	6686.5	11137.8	10032.1	11083.5
Төвийн бүс	1019.3	935.8	1188.3	937.4	1508.9
Дорноговь аймаг	18.4	13.2	12.7	12.1	55.6
Улсын дүнд эзлэх хувь	0.3	0.2	0.1	0.1	0.5
Бүсийн дүнд эзлэх хувь	1.8	1.4	1.1	1.3	3.7

Дорноговь аймгийн аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний борлуулалт нь 2016 онд улсын дүнд 0.5 хувь, бүсийн дүнд 3.9 хувийг тус тус эзэлж байна. Бүтээгдэхүүний борлуулалтын улсын дүнд эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 0.4 пунктээр буурч, бүсийн дүнд эзлэх хувь 2.6 пунктээр өссөн үзүүлэлт гарчээ.

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 7.4 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 90.8 хувиар нэмэгдлээ.

ХҮСНЭГТ4. БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, салбар, дэд салбар, дүнд эзлэх хувиар

Салбар	2014	2015	2016
Дүн	100.0	100.0	100.0
Уул уурхай олборлох аж үйлдвэр	34.4	16.6	40.7
Нүүрс олборлолт	24.3	13.9	40.7
Бусад ашигт малтмал олборлолт	10.1	2.7	0.0
Боловсруулах аж үйлдвэр	12.3	13.6	34.5
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	4.4	7.4	5.7
мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	0.4	0.4	3.8
сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	0.5	0.7	0.3
хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	3.5	6.2	1.6
Хувцас үйлдвэрлэл	0.5	0.6	0.2
Гутал үйлдвэрлэл	0.2	0.1	0.0
Мод, модон эдлэл үйлдвэрлэл	0.2	0.4	0.1
Машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл	0.0	0.0	0.0
Боловсруулах үйлдвэрийн бусад	7.0	5.0	28.5
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж	53.3	69.9	24.8
Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл	0	0	0
Ус ариутгал, усан хангамж	41.9	56.6	20.1
	11.4	13.3	4.7

Дээрх хүснэгтээс харахад бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг дэд салбараар нь авч үзвэл 2016 онд уул уурхайн салбар 40.7 хувь, боловсруулах аж үйлдвэрийн салбар 34.5 хувь цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамжийн салбар 20.1 хувийг тус тус эзэлж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад уул, уурхайн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл 24.1 пунктээр, боловсруулах аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 20.9 пунктээр өссөн нь 2016 онд аймгийн хэмжээнд аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт борлуулалт өсөхөд нөлөөлсөн юм.

ХҮСНЭГТ5. АЖ ҮЙЛДВЭРИЙН МЭДЭЭНД ХАМРАГДСАН АЖ АХУЙН НЭГЖ, ИРГЭДИЙН ТОО

Салбар	ААН	ИРГЭН
Дүн	26	95
Уул уурхай олборлох аж үйлдвэр	2	
Нүүрс олборлолт	2	
Бусад ашигт малтмал олборлолт		
Боловсруулах аж үйлдвэр	22	93
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	13	49
мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	1	
сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	1	
хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	11	49
Хувцас үйлдвэрлэл		17
Гутал үйлдвэрлэл		2
Мод, модон эдлэл үйлдвэрлэл		9
Машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл		3
Боловсруулах үйлдвэрийн бусад	9	16
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж	2	2
Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл	2	2
Ус ариутгал, усан хангамж		

Сар бүрийн аж үйлдвэрийн салбарын мэдээнд нийт 121 нэгж хамрагдсанаас 95 нь өрхийн аж ахуй эрхэлсэн иргэд байна. Үйлдвэрлэлийг аж үйлдвэрийн дэд салбараар нь ангилж үзвэл цахилгаан, хий, усан хангамжийн үйлдвэрлэл 24.8 хувь, уул уурхай, олборлох салбарын үйлдвэрлэл 40.7 хувь, боловсруулах салбарын бусад үйлдвэрлэл 34.5 хувийг тус тус эзэлж байна.

2016 онд боловсруулах үйлдвэрлэл-1, блокны үйлдвэрлэл -1, вакуум цонхны үйлдвэрлэл-1, цементны үйлдвэрлэл -1, нүүрсний үйлдвэрлэл -1, мах боловсруулах үйлдвэрлэл нэг тус тус шинээр нэмэгджээ.

ХҮСНЭГТ 6. БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, гол нэр төрлөөр, биет хэмжээгээр

	Хэмжих нэгж	2012	2013	2014	2015	2016	2016 2015
Цахилгаан	мян.кв.цаг	244.7	401.1	443.8	359.8	307.1	85.4
Дулаан	мян.ккал	60.3	68.5	68.9	80	110.5	138.1
Төмрийн хүдэр	мян.тн			4.6	36.4		0.0
Хайрга	мян.м3			37.1		17.4	
Талх	тн	54.8	91.1	83.0	160.5	112.33	70.0
Нарийн боов	тн	55.1	45.4	51.0	71.3	62.6	87.8
Бялуу	тн	1.3	3.4	1.75	3.00	2.2	73.3
Архи	мян.л	3.6	2.8				
Хиам	тн	9.9	9.0	7.8	8.4	8.3	98.8
Зайрмаг	мян.шир	42.9	22.7	5.8		0.8	
Модон эдлэл	мян.төг	14719.0	38970.0	19146.0	40043.0	38977.7	97.3
Жижиг төмөр эдлэл	мян.төг	1039.5	1814.0	1334.5	4933.0	745	15.1
Дээл тэрлэг	шир	601	481	442	499	416	83.4
Цонх	м2	2707.2	2083.5	2870.9	1264.6	1377.3	108.9
Оёдол	мян.төг	14133.1	17419.8	36227.4	38798.8	33279.8	85.8
Нүүрс	мян.тн	159.3	198.8	103.0	6.2	442.9	7143.5
Блок	мян.шир	66.4	136.9	82.9		49.3	
Тоосго	сая.ш			1.4			
Бетон зуурмаг	м3			3687		362.2	
Савласан цэвэр ус	мян.л	636.8	1723.7	2533.6	3096.1	2651.4	85.6
Сувагжуулалт	мян.м3	288.8	273.9	414.1	491	601.3	122.5
Ус түгээлт	мян.м3	475.4	488.2	673.3	671.8	810.8	120.7

2016 онд өмнөх оноос дулаан 38.1 хувь, цонх 8.9 хувь, сувагжуулалт 22.5 хувь, ус түгээлт 20.7 хувиар нэмэгдсэн байна. Нүүрсний үйлдвэрлэлт 2016 онд өмнөх оны мөн үеэс 71.4 дахин өссөн нь аймгийн хэмжээний нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт нөлөөлжээ.

ХҮСНЭГТ 7. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН АЖИЛЛАГЧДЫН ТОО

Салбар	2012	2013	2014	2015	2016	2015 2016
Бүгд	1024	859	1095	841	1142	135.8
Олборлох үйлдвэр	529	321	459	170	269	158.2
Боловсруулах үйлдвэр	177	204	201	309	474	153.4
Цахилгаан хий үйлдвэрлэл, ус хангамж	318	334	435	362	399	110.2

Аж үйлдвэрийн салбарын статистикийн мэдээнд хамрагдсан байгууллагын ажиллагчдын тоо өмнөх оноос 35.8 хувиар өссөн байна. Салбараар авч үзвэл уул уурхайн олборлох салбарын ажиллагчдын тоо өмнөх оноос 58.2 хувиар, цахилгаан хий,

усан хангамжийн салбарын ажилчдын тоо 10.2 хувиар, боловсруулах аж үйлдвэрийн салбарын ажиллагчдын тоо 53.4 хувиар тус тус өссөн байна.

Аж үйлдвэрийн салбарын 2016 оны хөдөлмөрийн бүтээмж нь 2015 оноос 38.2 хувиар өссөн байна.

ХҮСНЭГТ8. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖ, салбар, дэд салбараар, мян төг

Салбар	2013	2014	2015	2016	2016 2015
ДҮН	10947.4	10107.2	12496.3	29775.4	2.4 ²
Уул уурхай олборлох аж үйлдвэр	17076.3	7986.8	9688.2	54465.8	5.6 ²
Нүүрс олборлолт	17076.3	9679.1	27439.1	54465.8	198.5
Бусад ашигт малтмал олборлолт		5622.6	2221.6		0.0
Боловсруулах аж үйлдвэр	3525.7	7178.6	4708.1	23272.3	4.9 ²
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	3940.5	6165.6	5446.8	11560.1	2.1 ²
Хувцас үйлдвэрлэл	1755.0	2975.0	1612.8	2955.0	183.2
Гутал үйлдвэрлэл	557.1	2782.9	3225.8	5450.0	169.0
Мод, модон эдлэл үйлдвэрлэл	3890.0	6333.3	3640.3	3636.4	99.9
Машин тоног төхөөрөмжөөс бусад					
төмөр эдлэл үйлдвэрлэл	1342.9	346.0	822.2	700.0	85.1
Боловсруулах үйлдвэрийн бусад	5594.8	10266.3	5374.3	32055.0	5.9 ²
Цахилгаан, дулааны эрчим хүч					
үйлдвэрлэлт, усан хангамж	13415.3	13755.0	20513.7	21969.9	107.1
Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл	10766.0	13521.9	22204.7	33363.1	150.3
Ус ариутгал, усан хангамж	15896.0	14684.9	15478.1	8888.9	57.4

Тайлбар: ² дахин их

ГУРАВ. БАРИЛГЫН САЛБАР

2016 онд нийт 17046.2 сая төгрөгийн шинэ барилга, өргөтгөл, шинэчлэлт, их засварын ажил хийсэн нь өмнөх онтой харьцуулахад 59.6 хувиар буурсан байна. Барилгын нийт хөрөнгө оруулалтын 15.1 хувийг улсын төсвийн, 13.9 хувийг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар, үлдэх хувийг хөрөнгө оруулалтын бусад эх үүсвэрээр санхүүжүүлжээ.


Барилга угсралт их засварын ажлын 28.9 хувь нь орон сууцны барилга, 40.2 хувь нь орон сууцны бус барилга, 27.9 хувь нь инженерийн барилга, байгууламж, 3.0 хувь нь их засварын ажил байна.

Өмнөх оны мөн үеийнхээс инженерийн барилга, байгууламжийн эзлэх хувь 9.9 пунктээр буурч, орон сууцны барилгын эзлэх хувь 6.9 пункт, орон сууцны бус барилгынх 2.7 пункт, их засварын ажлынх 0.3 пунктээр өссөн байна.

ХҮСНЭГТ9. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, оны үнээр, сая төгрөг

	2012	2013	2014	2015	2016
Улсын дүн	919681.9	1719508.8	2146796.3	2290540.3	2482407.0
Төвийн бүс	37706.6	201893.4	385925.2	317761.1	176338.0
Дорноговь аймаг	4501	60509.1	79647,4	28878.8	17046.2
Улсын дүнд эзлэх хувь	0.5	3.5	5.4	1.3	0.7
Бүсийн дүнд эзлэх хувь	11.9	30	30	9.2	9.7

ЗУРАГ 6. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, төрлөөр, мян төг



ХҮСНЭГТ10.БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ сая төгрөг, сумаар

	2012	2013	2014	2015	2016	2016 2015
ДҮН	28051	159534.9	115802.4	42185.2	17046.2	40.4
Айраг	1199.8	428.1	1911.6	1320.8		0.0
Алтанширээ	134.3	26	383.2	205	99	48.3
Даланжаргалан	489.7	96.7	1599.4	2015.8		0.0
Дэлгэрэх	109.8	274	663		206.3	0.0
Иххэт	90.5		53.9	52.4	840.5	1604.0
Мандах	18.5	17.5	307.9	4	151.8	3795.0
Өргөн	53	2.1	3848.3	1157.4	1855.9	160.4
Сайхандулаан	509.3	8.7	208.8	91.1	73.5	80.7
Улаанбадрах	39.6	75	262	338.9	48.5	14.3
Хатанбулаг	439.7	604.4	5687.4	1398	1558.5	111.5
Хөвсгөл	313	500.7	417.3	243.7		0.0
Эрдэнэ	82.6		1500.5	154	417	270.8
Сайншанд	16263	77840.8	42748.6	19609.1	9804.9	50.0
Замын-Үүд	8307.6	79660.9	56210.5	15595	1990.3	12.8

Тайлбар: 2010-2013 оны барилга угсралт их засварын ажлын дүнд гадаадын байгууллагын гүйцэтгэгчдийн барилга угсралт их засварын ажил орсон болно.

ХҮСНЭГТ11.АШИГЛАЛТАНД ОРУУЛСАН ОРОН СУУЦ, м2, оны эцэст

	2012	2013	2014	2015	2016	2016 2015
Нийт талбай	25199.5	37030.5	30548.0	17483.8	6453.0	37.1
Төрийн хувийн	25199.5	37030.5	30548.0	17379.8	6453.0	37.1
Сууцны талбай	20343.7	30062.6	21648.5	13599.3	5615.0	41.5
Төрийн Хувийн	20343.7	30062.6	21648.5	13535.3	5615.0	41.5

ЗУРАГ 7. АШИГЛАЛТАНД ОРУУЛСАН ОРОН СУУЦАНД АМЬДАРЧ БУЙ өрх, хүн амын тоо



ДӨРӨВ. ЗАМ ТЭЭВЭР

Дорноговь аймгийн хэмжээнд 3000 гаруй км авто замтай бөгөөд үүнээс Чойр-Сайншанд-Замын-үүд чиглэлийн босоо тэнхлэгийн улсын чанартай 434.1 км хатуу хучилттай авто зам эзэлдэг. Тус авто замаас айраг хүртэл 1.7 км, Эрдэнэ сум хүртэл 15.5 км, Даланжаргалан сум хүртэл 1.1 км хатуу хучилттай авто замаар тус тус холбогдсон. 2016 онд Сайншанд сумын 1-р багт Аюушийн хэсэгт 0.236 км авто зам ашиглалтанд оржээ.

ХҮСНЭГТ12.АВТО ТЭЭВРИЙН ҮЗҮҮЛЭЛТ, оны эцэст

	хэмжих нэгж	Онууд					2016 2015
		2012	2013	2014	2015	2016	
1. Ачаа эргэлт	м.тн.км	32240.0	42478.0	23153.0	11238.0	18818.0	167.4
2. Тээсэн ачаа	мян.тн	133.8	156.8	85.0	50.9	85.3	167.6
3. Зорчигч эргэлт	м.хүн.км	3653.2	3947.4	1470.1	1314.0	1242.0	94.5
4. Зорчигчид	мян.хүн	94.6	102.5	77.5	55.5	51.3	92.4
5. ТҮ-ийн орлого	сая.төг	2467.0	10273.2	7991.3	6489.5	6781.0	104.5
6. Хамрагдсан нэгж	тоо	4	6	6	6	6	100.0

2016 онд 85.3 мянган тонн ачаа тээвэрлэж, 18818.0 мянган тонн км-ын ажил, 51.3 мянган зорчигч тээвэрлэж 1242.0 мянган хүн км-ын ажил гүйцэтгэсэн байна.

ХҮСНЭГТ13. ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТЕХНИКИЙН ХЯНАЛТ ОНОШЛОГООНД ХАМРАГДСАН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛИЙН ТОО, сумдаар оны эцэст

	2014	2015	2016	Үүнээс:			
				Автомашин	Мотоцикль	Чиргүүл	Бусад
Айраг	402	373	443	339	93	10	1
Алтанширээ	163	153	183	174	8	1	0
Даланжаргалан	273	254	272	247	22	3	0
Дэлгэрэх	243	204	261	246	15	0	0
Иххэт	146	127	198	179	18	1	0
Өргөн	227	152	177	159	17	1	0
Сайхандулаан	193	184	202	184	17	0	1
Мандах	148	169	175	159	14	1	1
Улаанбадрах	161	163	162	156	5	1	0
Хатанбулаг	351	280	306	292	14	0	0
Хөвсгөл	186	170	177	173	2	1	1
Эрдэнэ	181	194	250	209	40	1	0
Сайншанд	4729	2219	2313	2099	82	109	23
Замын-Үүд	5865	2953	2605	2156	13	426	10
УБ болон бусад	5108	6461	11943	11069	45	749	80
Бүгд	13175	14056	19667	17841	405	1304	117

2016 онд хийгдсэн тээврийн хэрэгслийн техникийн хяналт оношлогооны мэдээгээр 19667 авто машин, тээврийн хэрэгсэл хамрагдсан нь өмнөх оноос 39.9 хувь буюу 5611-ээр өсчээ. Нийт тээврийн хэрэгслийн 65.4 хувийг суудлын, 21.9 хувийг ачааны автомашин, 0.3 хувийг автобус, 5.5 хувийг мотоцикл, 6.4 хувийг чиргүүл, 0.5 хувийг бусад механизмууд эзэлж байна.

ТАВ. ХОЛБОО

Шуудан холбооны үйлчилгээний орлого 1332.8 сая төгрөг болж өмнөх оноос 11.7 хувиар буурсан байна. Суурин телефон цэгийн тоо 2016 онд 2218 болж өмнөх оноос 9.6 хувиар буюу 231 хэрэглэгчээр буурсан байна.

Энэ онд нийт 10.3 мянган ширхэг албан бичиг, захидал, 564 ширхэг илгээмж (боодол) илгээсэн бол шуудангаар 357 зорчигч үйлчлүүлж 4.4 сая төгрөгийн орлого оруулжээ.

ХҮСНЭГТ14. ХОЛБОО, ШУУДАН, оны эцэст

	Хэмжих нэгж	2012	2013	2014	2015	2016	2016 2015
Үйлчилгээний орлого	сая.төг	1025.7	1035.0	1257.7	1509.2	1332.8	88.3
Телефон яриа	мян.мин	768.1	622.4	632.8	512.5	512.5	100.0
Телефон цэг	тоо	2898	2678	2654	2449	2218	90.6
Захидал	мян.шир	0.9	0.7	0.7	0.9	1.1	122.2
Боодол	ширхэг	222	246	395	836	417	49.9
Албан бичиг	мян.шир	9.0	10.0	11.7	10.2	10.3	101.0
Илгээлт	ширхэг	133	155	189	171	147	86.0
Буухиа	тоо	146	149	116	112	59	52.7
Зорчигчийн тоо	хүн	1599	580	556	905	357	39.4
Хамрагдсан нэгж	тоо	3	3	3	4	4	100.0

2016 онд Дорноговь аймагт үүрэн телефоны оператор 4 компанийн салбар ажиллаж байгааг байршлаар авч үзвэл юнителын 15, мобикомын 14, скайтелын 13, G-mobile 12, суурин телефон цэг 7 суурин газарт нийт 61 салбар нэгж сум, суурин газруудад үйлчилгээ үзүүлжээ.

Үүрэн телефоны салбарууд энэ онд нийт 4119.0 сая төгрөгийн орлоготой ажилласан нь өмнөх оныхоос 14.2 хувиар өсчээ.

ХҮСНЭГТ15. ТЕЛЕФОН УТАСНЫ СҮЛЖЭЭНИЙ БАЙРШИЛ 2016 оны 12-р сарын 31 -ний байдлаар

	МЦХК	Mobicom	Skytel	Unitel	G.mobile	дүн
1 Айраг						4
2 Алтанширээ						5
3 Даланжаргалан						4
4 Дэлгэрэх						4
5 Иххэт						2
6 Мандах						4
7 Өргөн						4
8 Сайхандулаан						4
9 Улаанбадрах						4
10 Хатанбулаг						3
11 Хөвсгөл						3
12 Эрдэнэ						4
13 Сайншанд						5
14 Зүүнбаян						5
15 Замын үүд						5
Дүн	7	14	13	15	12	61

ХҮСНЭГТ16. ҮҮРЭН ТЕЛЕФОНЫ ҮЗҮҮЛЭЛТ, оны эцэст

	Хэмжих нэгж	2012	2013	2014	2015	2016	2016 / 2015
Үүрэн телефон хэрэглэгчээс орсон орлого	сая.төг	3677.9	3892.0	4226.0	3606.0	4119.0	114.2
Үүрэн телефон хэрэглэгчидийн тоо /давхардсан тоогоор/	тоо	63100	69920	76220	67400	69670	103.4
Хамрагдсан нэгж	тоо	4	4	4	4	4	100.0

Үүрэн телефон хэрэглэгчдийн тоо (давхардсан тоогоор) 69.7 мянга орчим байгаа нь өмнөх оноос 2.2 мянган хэрэглэгчээр нэмэгджээ.

ДҮГНЭЛТ

Аж үйлдвэрийн салбарын эдийн засгийн үзүүлэлтүүдэд аж ахуйн нэгж байгууллагын зардал, бүтээгдэхүүний үйлдвэрлэлт биет хэмжээ, үнийн дүнгээр, бүтээгдэхүүний борлуулалт, үндсэн хөрөнгө болон санхүүгийн байдлыг харуулсан үзүүлэлтүүдийг оруулдаг. Тэдгээр үзүүлэлтүүдийг гаргах мэдээллийн эх сурвалж нь үйлдвэрийн газруудын сар, улирал, жилийн тайлан болно.

Аж үйлдвэрийн борлуулалт нь улсын дүнд эзлэх хувь 2012-2016 жилүүдэд 0.3-0.5 хувь, бүсийн дүнд 1.8-3.7 хувь болж өсч байна. Үйлдвэрлэлийг аж үйлдвэрийн дэд салбараар нь ангилж үзвэл цахилгаан, хий, усан хангамжийн үйлдвэрлэл 24.8 хувь, уул уурхай, олборлох салбарын үйлдвэрлэл 40.7 хувь, боловсруулах салбарын бусад үйлдвэрлэл 34.5 хувийг тус тус эзэлжээ.

Аж үйлдвэрийн салбарын статистикийн мэдээнд хамрагдсан байгууллагын ажиллагчдын тоо өмнөх оноос 35.8 хувиар өссөн байна. Салбараар авч үзвэл уул уурхайн олборлох салбарын ажиллагчдын тоо өмнөх оноос 58.2 хувиар, цахилгаан хий, усан хангамжийн салбарын ажилчдын тоо 10.2 хувиар, боловсруулах аж үйлдвэрийн салбарын ажиллагчдын тоо 53.4 хувиар тус тус өссөн байна.

Барилга угсралт, их засварын ажил 2010 оноос хойш өссөн байна. Энэ нь сүүлийн жилүүдэд орон сууцны барилга угсралтын ажил нэмэгдсэнтэй холбоотой юм. Улсын дүнд эзлэх хувь 2015 онд 1.3 хувь, 2016 онд 0.7 хувь, бүсийн дүнд эзлэх хувь 2015 онд 9.2 хувь, 2016 онд 29.6 хувийг эзэлж байна. Нийт барилга угсралтын ажилд орон сууцны барилгын гүйцэтгэл 2012 онд 7.9 хувь 2013 онд 44.8 хувь, 2014 онд 32.5 хувь, 2015 онд 22.0 хувь, 2016 онд 28.9 хувийг эзэлж байна.

Барилгын нийт хөрөнгө оруулалтын 15.1 хувийг улсын төсвийн, 13.9 хувийг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар, үлдэх хувийг хөрөнгө оруулалтын бусад эх үүсвэрээр санхүүжүүлжээ.

Барилга угсралт их засварын ажлын 28.9 хувь нь орон сууцны барилга, 40.2 хувь нь орон сууцны бус барилга, 27.9 хувь нь инженерийн барилга, байгууламж, 3.0 хувь нь их засварын ажил байна.

Өмнөх оны мөн үеийнхээс инженерийн барилга, байгууламжийн эзлэх хувь 9.9 пунктээр буурч, орон сууцны барилгын эзлэх хувь 6.9 пункт, орон сууцны бус барилгын эзлэх хувь 2.7 пункт, их засварын ажлын эзлэх хувь 0.3 пунктээр өсчээ.

АШИГЛАСАН НОМ, МАТЕРИАЛ

1. www.1212.mn
2. www.dornogovi.nso.mn.
3. Дорноговь аймгийн Статистикийн эмхэтгэл 2016 онд

Хянасан: Статистикийн хэлтсийн дарга

Боловсруулсан: Ахлах мэргэжилтэн

Мэргэжилтэн

Х.Өлзийсүрэн

Б.Цэрэндорж

А.Амарзаяа